

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 07

№ 24/ТУЗ/06

Улаанбаатар хот

‘ Ногдол ашиг хуваарилах тухай ’

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12, Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.14.10, Компанийн Ногдол ашгийн бодлогын холбогдох заалт болон Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны 2 сарын 07-ны өдрийн хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монложистикс Холдинг” ХК-ийн 2023 оны санхүүгийн жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 7,58 (долоон төгрөг тавин найман мөнгө) төгрөгөөр тогтоож, Компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 35 (гучин тав) хувийг буюу 3,000,609,870.76 (гурван тэрбум зургаан зуун есөн мянга найман зуун далан төгрөг далан зургаан мөнгө) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон хуулийн этгээлийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2024 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн дотор олгосугай.
4. Ногдол ашгийг тогтоосон хугацааны дотор хуваарилах, олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, холбогдох татвар суутгах, ногдол ашиг хуваарилалтын тайланг зохицуулагч байгууллагуудад хүргүүлэх зэргээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, ТУЗ-д тайлагнаж ажиллахыг “Монложистикс Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГАНЗОРИГТ